

“Ган нэгдэл” ХК-ийн хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл болон “Ган нэгдэл” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2008 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах Хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Ган нэгдэл” ХК-ийн 63954 ширхэг нийтэд санал болгон гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн жагсаалт, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, “Хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын талаар нийтэд мэдээлж, жижиг хувьцаа эзэмшигчидтэй тооцоо хийж дуусган 2008 оны 2 дугаар улиралд багтаан Хороонд мэдэгдэхийг “Ган нэгдэл” ХК /Л.Төмөрбаатар/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын талаар Үндэсний татварын ерөнхий газрын харьяа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ